



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулах,
ажилтны ёс зүйн дүрэм болон ёс зүйн дэд
хорооны ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтны ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах, тайлан мэдээг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллах ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	Т.Хоролсүрэн	Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Энхчимэг	Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч
	Ц.Батгэрэл	Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн дарга
	Г.Анхцэцэг	Авто замын төв лабораторийн эрхлэгч
	Г.Ариунчимэг	Барилга угсралтын хэлтсийн хяналтын инженер
	Э.Лхамсүрэн	Авто замын ашиглалтын хэлтсийн төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Т.Батболд	Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн Төсвийн магадлал хариуцсан ахлах мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	М.Амармэнд	Хууль, гэрээний мэргэжилтэн

1426011005

2. Байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгдүгээр, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3. Шинэчлэн баталсан “ажилтны ёс зүйн дүрэм”-ийг нийт ажилтнуудад танилцуулж, мөрдүүлэх, ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллахыг ёс зүйн дэд хороо (Т.Хоролсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны санхүүжилт болон ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний урамшууллыг холбогдох журамд заасны дагуу батлагдсан төсөвт багтаан тооцож олгохыг Санхүү хөрөнгө оруулалтын алба (Б.Энхчимэг)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тус хорооны гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулахыг Захиргааны хэлтэс (Д.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан үйлдвэрийн газрын захирлын 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/250 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Д.ОЮУНБОЛД